



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/22

Мөрөн сум

Өсвөрийн шигшээ багийн ажиллуулах
журам батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Биеийн тамир, спортын газрын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн бүтцийг нэгдүгээр хавсралтаар, үйл ажиллагааг зохицуулах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын үйл ажиллагаа, хэрэгжилтийг хангаж, шаардлагатай зардлыг жил бүрийн төсөвт тусгуулан ажиллахыг Биеийн тамир, спортын газрын дарга (Б.Баярсайхан) -д даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх) -т үүрэг болгосугай.

ДАРГА




П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
1 дүгээр сарын 1-ний өдрийн А/... дугаар
захирамжийн нэг дүгээр хавсралт

АЙМГИЙН ӨСВӨРИЙН ШИГШЭЭ БАГИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО

Өсвөрийн шигшээ багийг хариуцан ажиллах ажилтан (Биеийн тамир спортын
газрын спортын албаны дарга)



**ӨСВӨР ҮЕИЙН ШИГШЭЭ БАГ АЖИЛЛУУЛАХ, САНХҮҮЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Нэг. Үндэслэл

1.1. "Биеийн тамир, спортын тухай" хууль, Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 189 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэн, аймагт өсвөр үеийн шигшээ баг байгуулан, өсөх ирээдүйтэй, авьяаслаг хүүхэд, залуучуудыг сонгон шалгаруулж, ур чадвар, амжилтыг ахиулах сургалтын тогтолцоо, нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

1.2. Өсвөр үеийн болон оюутны шигшээ баг нь үндэсний хэмжээнд авьяастай тамирчдыг нэгдсэн хөтөлбөр, бодлогын дагуу системтэй бэлтгэх залгамж чанар бүхий нэгдмэл тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг мөн.

1.3. Аймагт өсвөр үеийн, шигшээ багийг байгуулах, түүний үйл ажиллагаатай холбоотой нийтлэг харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Шигшээ багийг байгуулах

2.1. Аймагт өсвөр үеийн шигшээ баг бүрдүүлэх спортын төрлүүдийг сонгон шалгаруулах:

2.1.1. Өсвөр үеийн шигшээ багийг Аймгийн Засаг даргын шийдвэрээр Биеийн тамир спортын газрын харьяанд байгуулна.

а/ Өсвөр үеийн шигшээ багийг аймагт найм ба түүнээс цөөн төрөл байхаар

2.1.2. Аймагт өсвөр үеийн шигшээ багийн асуудлаар Зөвлөл байгуулж ажиллуулна.

2.1.3. Зөвлөл нь энэхүү журам болон холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, шигшээ багийн үйл ажиллагааны явц, төсөв хөрөнгийн зарцуулалт, үр дүн зэрэгт хяналт тавьж, шигшээ баг байгуулах спортын төрөл, багш, дасгалжуулагч, тамирчдыг сонгон

шалгаруулж, шигшээ багийн үйл ажиллагаа, арга хэмжээний чиглэл, төлөвлөгөөг баталж, тухайн шатны Засаг даргаар холбогдох шийдвэрийг гаргуулан хэрэгжилтийг хангах үүрэгтэй.

2.1.4. Аймагт өсвөр үеийн шигшээ багийг байгуулах спортын төрлүүдийг сонгон шалгаруулахдаа дараах үзүүлэлтүүдийг үндэс болгоно.

Үүнд:

а/ Аймаг, хот, улс, олон улсын тэмцээнд оролцсон амжилт, авсан медаль

б/ Тухайн спортын төрлөөр тухайн аймагт сургалт тогтмол явуулж, уралдаан тэмцээнд баг тамирчдаа бэлтгэн оролцуулдаг багш, дасгалжуулагчдын тоо

в/ Тухайн төрлийн сургалтыг зохион байгуулах заал, талбай материаллаг баазын хүртээмж

2.2. Аймагт өсвөр үеийн шигшээ багийн дасгалжуулагчдыг сонгон шалгаруулах:

2.2.1. Өсвөр үеийн шигшээ багийг зохион байгуулалтын ямар хэлбэрээр ажиллуулах талаар тухайн төрлийн Спортын холбоотой зөвшилцсөний үндсэн дээр уг спортын онцлогтой уялдуулан дасгалжуулагч сонгох ажлыг хэрэгжүүлнэ.

2.2.2. Өсвөр үеийн шигшээ багийн төрөл тус бүрд 1 дасгалжуулагчтай байхыг зөвшөөрнө.

2.2.3. Өсвөр үеийн шигшээ багийн дасгалжуулагчдыг удирдах ур чадвар, мэргэжлийн мэдлэг, туршлага, манлайллын чадамж, сонирхол, санаачилга, зүтгэл, спортын холбоодын санал зэрэг үзүүлэлтээр шалгаруулж, аймгийн Биеийн тамир, спортын газраас батлан 3-5 жилийн гэрээ байгуулж ажиллуулна.

2.2.4. Өсвөр үеийн шигшээ багт гадаад, дотоодын өндөр мэргэжлийн дасгалжуулагчийг гэрээний үндсэн дээр тодорхой хугацаагаар ажиллуулж болно.

2.2.5. Өсвөрийн шигшээ багт ажиллах эмч, илээч, судлаач, сэтгэл зүйч, зөвлөгч, мэргэжилтэн, менежер зэрэг бүрэлдэхүүнийг тухайн шатны шигшээ баг хариуцсан Биеийн тамир, спортын байгууллага нь батлагдсан төсөв, орон тоондоо багтаан томилох буюу гэрээ байгуулан ажиллуулж болно.

2.2.6 Өсвөр үеийн шигшээ багийг дасгалжуулж байгаа багш дасгалжуулагчтай хийсэн гэрээг ямар тохиолдолд цуцлахыг гэрээндээ тодорхой тусгаж өгсөн байна. Үүнд:

- Спортын амжилт, сахилга бат, дэг журам, харьцаа хандлага, ёс зүй зэрэг зүйл заалт хангаагүй тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

2.2.7 Өсвөрийн шигшээ багийг дасгалжуулж байгаа дасгалжуулагч нар ажлын байран дээр болон тэмцээ уралдаанд тамирчдаа оролцуулах үедээ мөн бэлтгэл дасгалжуулалтын үед харьцаа хандлагын, ёс зүйн, бэлтгэл дасгалжуулалтын сурган хүмүүжүүлэх үеийн алдаа дутагдал гаргасан тохиолдолд хөдөлмөрийн тухай хууль бусад хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна.

Гурав. Шигшээ багийн тамирчдыг сонгон шалгаруулах

3.1. Өсвөрийн шигшээ багт 18 ба түүнээс доош насны анхан шатны нэгжүүдээс спортын амжилтаараа шалгарсан цаашид спортын тухайн төрлөөр тууштай хичээллэж, амжилт, ур чадвараа дээшлүүлэх сонирхолтой тамирчдыг багийн дасгалжуулагчийн дүгнэлт тодорхойлолт, холбооны удирдах зөвлөлийн дийлэнх олонхын хувийн ирцтэй хурлаар оруулж дэмжсэн протокол, санал, болон эрүүл мэндийн магадалгааг үндэслэн аймгийн Биеийн тамир, спортын газрын шийдвэрээр элсүүлэн хичээллүүлнэ.

3.2. Өсвөрийн шигшээ багт элсэхээр нэр дэвшсэн тамирчин нь, тухайн спортын төрлийн бие бялдрын болон техникийн бэлтгэлжилтийн өөрийн насны норматив үзүүлэлтүүдийн шаардлагыг биелүүлсэн, сүүлийн 3 жилд аймаг, хот, улсын аварга шалгаруулах тэмцээнд тогтмол оролцож, ур чадвар, амжилтаа ахиулсан байх шаардлагатай.

3.3. Өсвөр үеийн шигшээ багийн бүрэлдэхүүний талаарх асуудлыг жил бүрийн 12 дугаар сард багтаан хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд шигшээ багт нэр дэвшүүлэх тамирчны талаарх мэдээлэл, судалгаа санал хүсэлт, тодорхойлолтыг тухайн спортын холбоогоор дамжуулан аймгийн Биеийн тамир, спортын газар 3 сарын өмнө ирүүлсэн байна.

3.4. Өсвөр үеийн шигшээ багийн тамирчныг шалгаруулах, шинэчлэх, солих үйл ажиллагааг спортын шударга өрсөлдөөний зарчимд тулгуурлан нээлттэй хэлбэрээр зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байна.

3.5. Өсвөр үеийн шигшээ багийн тамирчин нь давхар Залуучуудын болон насанд хүрэгчдийн шигшээ багийн гишүүн байж болно.

Дөрөв. Шигшээ багийг санхүүжүүлэх

4.1. "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 20.3-т заасны дагуу Өсвөр үеийн шигшээ багийн холбогдох зардлыг аймгийн төсөвт жил бүр тусган батлуулна.

4.2. Өсвөр үеийн шигшээ багийг аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Засаг даргатай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулсны үндсэн дээр санхүүжүүлнэ.

4.3. Өсвөрийн үеийн шигшээ багийн дасгалжуулагчийн зардлыг шийдвэрлэнэ.

4.4. Нэг тамирчин нь энэхүү журмын 2.3.5 д зааснаар шигшээ багийн 2 шатлалд зэрэг хамрагдаж байгаа нөхцөлд шигшээ багуудын хангамжийн нэр төрлүүдийг давхардуулан олгохгүй.

4.5. Өсвөр үеийн шигшээ багийн тамирчдаас олимп, тивийн наадам, өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн тив, дэлхийн аварга, дэлхийн цом, олимпын эрх авах цуврал тэмцээнд оролцох зардал, хангамжийг орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлж зохион байгуулна.

4.6. Өсвөр үеийн шигшээ багийн батлагдсан төсвийг захиран зарцуулах эрхийг аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга эдэлнэ.

4.7. Шигшээ багийн дараа жилийн үйл ажиллагааны төсвийн төслийг жил бүрийн 06 дугаар сарын 15-ний дотор тухайн шатны төсвийн Ерөнхийлөн захирагчид гаргаж өгнө.

4.8. Тамирчид, дасгалжуулагчдын цалин хангамж сургалт дасгалжуулалтын чанар, үр дүнтэй нягт уялдсан, шударга өрсөлдөөнийг идэвхжүүлэх хөшүүрэг байх нөхцөлийг гэрээгээр зохицуулна.

Тав. Үйл ажиллагаа

5.1. Өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг Монгол улсын хууль, Засгийн газрын тогтоол, Аймгийн Засаг даргын шийдвэр болон бусад эрх бүхий байгууллагын шийдвэр, дүрэм, журамд нийцүүлэн явуулна.

5.2. Шигшээ багийн бэлтгэл, сургуулилт хийхэд шаардагдах нөхцөл, хангамжийг бүрдүүлэх асуудлыг аймгийн Биеийн тамир, спортын газар хариуцна.

5.3. Өсвөр үеийн шигшээ багийн сургалт дасгалжуулалтын хөтөлбөр, төлөвлөгөөг аймгийн Биеийн тамир, спортын газар, тухайн шигшээ багийг гэрээний үндсэн дээр хариуцан

ажиллаж байгаа байгууллага, клубтэй хамтран гаргаж, баталж хэрэгжилтийг хангаж ажиллана.

5.4. Бүх шатны шигшээ багийн тамирчдад спортын онол, сэтгэл зүй, хүмүүжил, ёс суртахуун, амьдрах ухааны сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу тэдний бие бялдрын бэлтгэлтэй эн тэнцүү хэмжээнд тогтмол явуулна.

5.5. Шигшээ багийн тамирчдын бэлтгэл сургуулилт, тэмцээнд оролцоход эмнэлгийн байнгын хяналт, тусламж, үйлчилгээгээр хангана.

5.6. Шигшээ багийн тамирчид, дасгалжуулагчид тухайн шатны Биеийн тамир, спортын газрын даргатай үйл ажиллагааны гэрээ 3-5 жилээр байгуулж ажиллана.